



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020.02.14 № 05/1941

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Ашигт малтмал, газрын тосны газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн төлөвлөгөө, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Төмөрбаатарын Батчимэгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Т.Батчимэг нь нэр дэвшиж буй албан тушаалын тусгай шалгалт өгөөгүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т "... тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг мөн хуулийн 27.1.1, 27.1.2-т заасан төрийн албан хаагчаас болон мөн хуулийн 27.1.3-т заасан нөөцөд байгаа иргэдээс тус тус авна", мөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2-т "Зөвлөл, Салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтын тайланг хянаж, шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ" гэж заасныг зөрчиж байна.

Иймд нэр дэвшигчийг Төрийн албаны тухай хууль болон түүнд нийцүүлэн гарсан тогтоол, журмыг баримтлан нэр дэвшиж буй албан тушаалд түр болон жинхлэн томилох эсэхийг дээрх хуульд заасны дагуу Төрийн албаны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн шийдвэрлэнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

УХА0422 5120829

0002753